



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хишиг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** БУА-2022/130/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Булган хот 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70342580 Цахим хаяг: Anhbayrd@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enhtsoodol@audit.gov.mn</p> <p>Аудитор: А.Сувдаа Утас: 70342495 Цахим хаяг: Suvdaaa@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	14
3.4 Материаллаг байдал .....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал .....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт .....	19
4.1 Залруулсан алдаа .....	19
4.2 Албан шаардлага .....	19
4.3 Зөвлөмж.....	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	0

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НА	Нийцлийн аудит
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлан
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**БУЛГАН АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-3259  
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 122

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

Г ХИШИГ-ӨНДӨР СУМЫН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА  
Ч.ТЭШИГМАА ТАНАА

Г **Хязгаарлалтай дүгнэлт** Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хишиг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хишиг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний байгууллагаас цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд тооллогыг Эрүүл мэндийн төвийн даргын А/20 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй комисс томилогдон 12 дугаар сарын 30-нд тооллогыг хийж дууссан бөгөөд тооллого хийгдсэнээс хойш 24,629,660.00 /хорин дөрвөн сая зургаан зуун хорин есөн мянга зургаан зуун жар/ төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж, бараа материалын хувьд 522,500.00 /таван зуун хорин хоёр мянга таван зуу/ төгрөгийн орлого, 12,953,111.31 / арван хоёр сая есөн зуун тавин гурван мянга нэг зуун арван нэгэн төгрөг гучин нэг/ мөнгөний зарцуулалт хөдөлгөөн хийгдсэн ч тооллогын дүн 12 дугаар сарын 31-ний үлдэгдлээр тоологдсон, 8,829,050.40 /найман сая найман зуун хорин есөн мянга тавин төгрөг дөч/ мөнгөний вакцин тоолсон баримт байхгүй тооллогыг үнэн зөв, бодиттой хийгээгүй, 2020 оны санхүүгийн тайлан сөрөг дүгнэлттэй, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.3, 16.5.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.4, 20.2.5-д заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй, эрх үүрэг, үнэн зөв болон тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

D:/bichighereg/2022A4foot

006020242

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 Д.АНХБАЯР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>45,415,971.89</b>	<b>274,009,872.52</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	12,731,243.94
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	12,731,243.94
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	12,731,243.94
31211	Төрийн сангийн харилцах	-	5,666,677.94
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	7,064,566.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	131,184,009.48
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	574,209.48
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	130,609,800.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	45,415,971.89	130,094,619.10
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	12,899,866.90	46,030,092.90
35130	Эм боох материал	12,899,866.90	46,030,092.90
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	28,710,104.99	84,064,526.20
35410	Бичиг хэргийн материал	840,180.00	3,176,650.00
35420	Аж ахуйн материал	19,916,589.00	70,780,812.20
35430	Сэлбэг хэрэгсэл	4,125,000.00	3,196,750.00
35440	Түлш, шатах тослох материал	2,866,590.00	3,255,512.00
35450	Барилгын засварын материал	85,500.00	-
35460	Хүнсний материал	179,879.99	3,654,802.00
35470	Бусад хангамжийн материал	696,366.00	-
35500	Биологийн хөрөнгө	3,806,000.00	-
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>709,920,737.62</b>	<b>722,224,314.33</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	709,920,737.62	722,224,314.33
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	692,666,737.62	703,873,439.33
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,392,983,519.51	1,392,983,519.51
39202	Хуримтлагдсан элэгдэл	(830,490,961.77)	(854,567,891.31)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	66,388,000.00	66,388,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(31,075,300.86)	(40,559,545.92)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	91,926,806.93	163,813,980.46
39206	Хуримтлагдсан элэгдэл	(19,771,441.69)	(43,106,701.10)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	21,253,700.00	21,253,700.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(4,907,584.50)	(8,055,622.31)
39214	Бусад үндсэн хөрөнгө	12,720,000.00	12,720,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(6,360,000.00)	(6,996,000.00)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	17,254,000.00	18,350,875.00
39301	Програм хангамж	-	1,350,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(253,125.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	17,254,000.00	17,254,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>755,336,709.51</b>	<b>996,234,186.85</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>-</b>	<b>522,500.61</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	522,500.61
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	522,500.61
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	522,500.61
41361	Байгууллагад төлөх өглөг	-	522,500.61
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>755,336,709.51</b>	<b>995,711,686.24</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	755,336,709.51	995,711,686.24
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	413,976,292.00	413,976,292.00
51101	Өмч: - төрийн	413,976,292.00	413,976,292.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(111,693,729.71)	128,681,247.02
51210	Өмнөх үеийн үр дүн	(111,693,729.71)	(111,693,729.71)
51220	Тайлант үеийн үр дүн	-	240,374,976.73

Хишиг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	453,054,147.22	453,054,147.22
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>755,336,709.51</u></b>	<b><u>996,234,186.85</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>671,828,408.10</b>	<b>1,407,507,448.72</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>116,189,488.10</b>	<b>292,983,528.72</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	56,873,618.10	292,983,528.72
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	56,873,618.10	292,983,528.72
1E+06	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	56,873,618.10	292,983,528.72
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	59,315,870.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	59,315,870.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>555,638,920.00</b>	<b>1,114,523,920.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	551,557,100.00	579,532,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	551,557,100.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	579,532,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	4,081,820.00	471,555,930.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,000,000.00	2,340,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,511,800.00	465,748,930.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,570,020.00	3,467,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	-	45,631,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	45,631,600.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	-	17,803,590.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	17,803,590.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>658,115,207.49</b>	<b>1,167,132,471.99</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>658,115,207.49</b>	<b>1,167,132,471.99</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	652,029,441.49	1,110,261,166.99
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	453,841,147.00	517,164,083.48
210101	Үндсэн цалин	262,370,803.00	256,783,509.08
210102	Нэмэгдэл	143,437,932.00	218,976,214.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,323,104.00	6,100,999.19
210104	Урамшуулал	40,709,308.00	35,303,360.33
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	56,490,468.00	60,430,789.00
210201	Тэтгэврийн даатгал	39,058,252.00	39,922,329.22
210202	Тэтгэмжийн даатгал	4,170,361.00	7,781,909.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,616,301.00	3,329,825.78
210204	Ажилгүйдлийн даатгал	876,867.00	1,033,034.90
210205	Эрүүл мэндийн даатгал	8,768,687.00	8,363,689.86
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	24,673,808.00	46,868,829.00
210301	Гэрэл, цахилгаан	5,475,213.00	6,348,354.00
210302	Түлш, халаалт	17,169,930.00	36,913,076.00
210303	Цэвэр, бохир ус	2,028,665.00	3,607,399.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	17,853,030.00	72,154,505.00
210401	Бичиг хэрэг	1,723,640.00	2,168,800.00
210402	Тээвэр, шатахуун	11,961,870.00	14,031,598.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	280,000.00	1,680,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,040,600.00	528,900.00

**Хишиг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,472,820.00	53,745,207.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	374,100.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>50,795,853.45</b>	<b>337,156,303.69</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	38,942,927.45	302,710,834.70
210502	Хоол, хүнс	11,852,926.00	20,354,252.99
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	14,091,216.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,044,500.00</b>	<b>6,683,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	300,000.00	866,000.00
210604	Урсгал засвар	1,744,500.00	5,817,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>984,000.00</b>	<b>1,321,330.00</b>
210702	Дотоод албан томилолт	984,000.00	1,321,330.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,472,050.00</b>	<b>1,429,630.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	133,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	747,500.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	140,000.00	668,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	158,390.00	48,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	67,400.00	67,000.00
210807	Газрын төлбөр	160,000.00	160,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	100,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,098,760.00	352,130.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>42,874,585.04</b>	<b>67,052,696.82</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,648,311.00	6,119,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	40,226,274.04	60,933,596.82
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>6,085,766.00</b>	<b>56,871,305.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>830,000.00</b>	<b>56,870,435.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	56,200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	830,000.00	670,435.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>5,255,766.00</b>	<b>870.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,255,766.00	870.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>13,713,200.61</b>	<b>240,374,976.73</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,045,344.18</b>	<b>-</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	330,201.35	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	2,715,142.83	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(3,045,344.18)</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>10,667,856.43</b>	<b>240,374,976.73</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	413,976,292.00	453,054,147.22	(125,450,828.97)		741,579,610.25
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>413,976,292.00</b>	<b>453,054,147.22</b>	<b>(125,450,828.97)</b>	-	741,579,610.25
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	13,757,099.26		13,757,099.26
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>413,976,292.00</b>	<b>453,054,147.22</b>	<b>(111,693,729.71)</b>	-	755,336,709.51
D01	<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>413,976,292.00</b>	<b>453,054,147.22</b>	<b>(111,693,729.71)</b>	-	755,336,709.51
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>413,976,292.00</b>	<b>453,054,147.22</b>	<b>(111,693,729.71)</b>	-	755,336,709.51
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-		-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	240,374,976.73		240,374,976.73
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>413,976,292.00</b>	<b>453,054,147.22</b>	<b>128,681,247.02</b>	-	995,711,686.24

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>614,954,790.00</b>	<b>984,358,204.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>59,315,870.00</b>	<b>444,084.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	444,084.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	444,084.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	444,084.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	59,315,870.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	59,315,870.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>555,638,920.00</b>	<b>983,914,120.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	551,557,100.00	579,532,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	551,557,100.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	579,532,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	4,081,820.00	340,946,130.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,000,000.00	2,340,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,511,800.00	335,139,130.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,570,020.00	3,467,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	-	45,631,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	45,631,600.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	-	17,803,590.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	17,803,590.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>613,113,790.00</b>	<b>930,216,360.06</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>613,113,790.00</b>	<b>930,216,360.06</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>607,028,024.00</b>	<b>873,345,055.06</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	453,841,147.00	518,182,376.96
210101	Үндсэн цалин	262,370,803.00	257,801,802.56
210102	Нэмэгдэл	143,437,932.00	218,976,214.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,323,104.00	6,100,999.19
210104	Урамшуулал	40,709,308.00	35,303,360.33
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	56,490,468.00	60,430,789.00
210201	Тэтгэврийн даатгал	39,058,252.00	39,922,329.22
210202	Тэтгэмжийн даатгал	4,170,361.00	7,781,909.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,616,301.00	3,329,825.78
210204	Ажилгүйдлийн даатгал	876,867.00	1,033,034.90
210205	Эрүүл мэндийн даатгал	8,768,687.00	8,363,689.86
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	19,617,928.00	44,562,929.00
210301	Гэрэл, цахилгаан	5,806,663.00	6,348,354.00
210302	Түлш, халаалт	11,528,800.00	34,607,176.00
210303	Цэвэр, бохир ус	2,282,465.00	3,607,399.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	20,845,370.00	85,133,650.00
210401	Бичиг хэрэг	1,472,990.00	4,807,400.00
210402	Тээвэр, шатахуун	13,828,460.00	14,427,120.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	280,000.00	1,680,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,321,920.00	2,993,980.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,942,000.00	61,225,150.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	46,596,620.00	146,177,190.10
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	33,740,820.00	119,038,690.10
210502	Хоол, хүнс	10,634,300.00	22,461,200.00

Хишиг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,221,500.00	4,677,300.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,080,000.00</b>	<b>10,340,190.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	881,000.00	2,540,190.00
210604	Урсгал засвар	2,199,000.00	7,800,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>984,000.00</b>	<b>1,321,330.00</b>
210702	Дотоод албан томилолт	984,000.00	1,321,330.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,772,680.00</b>	<b>1,121,400.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	133,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	747,500.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	140,000.00	712,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	158,390.00	48,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	67,400.00	67,000.00
210807	Газрын төлбөр	160,000.00	160,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	100,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,399,390.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,799,811.00</b>	<b>6,075,200.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,799,811.00	6,075,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>6,085,766.00</b>	<b>56,871,305.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>830,000.00</b>	<b>56,870,435.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	56,200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	830,000.00	670,435.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>5,255,766.00</b>	<b>870.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,255,766.00	870.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>1,841,000.00</u></b>	<b><u>54,141,843.94</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b><u>2,691,000.00</u></b>	<b><u>41,410,600.00</u></b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b><u>2,691,000.00</u></b>	<b><u>41,410,600.00</u></b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>2,691,000.00</b>	<b>41,410,600.00</b>
222001	Тоног төхөөрөмж	1,841,000.00	40,060,600.00
223001	Бусад хөрөнгө	850,000.00	1,350,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(2,691,000.00)</u></b>	<b><u>(41,410,600.00)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(850,000.00)</b>	<b>12,731,243.94</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	<b>12,731,243.94</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	698656900.00	637744526.06
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	698656900.00	629521326.06
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	697976900.00	628850891.06
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	491240600.00	453924069.96
210101	Үндсэн цалин	286653200.00	257801802.56
210102	Нэмэгдэл	161621000.00	155815673.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8568000.00	6100999.19
210104	Урамшуулал	34398400.00	34205594.33
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	66317400.00	53633594.00
210201	Тэтгэврийн даатгал	46667800.00	35169798.22
210202	Тэтгэмжийн даатгал	4912400.00	7298235.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	3929900.00	2894329.78
210204	Ажилгүйдлийн даатгал	982500.00	930715.90
210205	Эрүүл мэндийн даатгал	9824800.00	7340514.86
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	46301100.00	41980730.00
210301	Гэрэл, цахилгаан	5851500.00	5851154.00
210302	Түлш, халаалт	38927200.00	34607176.00
210303	Цэвэр, бохир ус	1522400.00	1522400.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	21168800.00	21153020.00
210401	Бичиг хэрэг	2003500.00	1997400.00
210402	Тээвэр, шатахуун	13927500.00	13925520.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,100,000.00	1,100,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	911,400.00	903,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,226,400.00	3,226,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	49,000,000.00	47,891,487.10
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	37,300,000.00	37,245,737.10
210502	Хоол, хүнс	9,600,000.00	8,546,850.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,100,000.00	2,098,900.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	14,488,200.00	3,277,390.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,188,200.00	977,390.00
210604	Урсгал засвар	2,300,000.00	2,300,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,469,000.00	354,000.00
210702	Дотоод албан томилолт	1,469,000.00	354,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,916,600.00	561,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	133,600.00	133,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	158,000.00	152,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	48,000.00	48,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	67,000.00	67,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,350,000.00	-
210807	Газрын төлбөр	160,000.00	160,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	6,075,200.00	6,075,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,075,200.00	6,075,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	680,000.00	670,435.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	680,000.00	670,435.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	680,000.00	670,435.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>8,223,200.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	8,223,200.00
222001	Тоног төхөөрөмж	-	6,873,200.00
223001	Бусад хөрөнгө	-	1,350,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	618,057,700.00	643,412,074.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	548,884,700.00	579,532,800.00

Хишиг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	525,043,100.00	579,532,800.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	23,841,600.00	-
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	45,631,600.00
132001	Орон нутгийн төсвөөс	-	45,631,600.00
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	17,803,590.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	17,803,590.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	444,084.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	444,084.00
<b>122</b>	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	69,173,000.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	69,173,000.00	-
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>5,666,677.94</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	33.00	33.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	20.00	20.00
620003	Үйлчлэх ажилтан	12.00	12.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>33.00</b>	<b>33.00</b>
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	20.00	20.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	13.00	13.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон		/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>333,881,564.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>300,694,164.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	244,494,164.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	64,258,307.00
210102	Нэмэгдэл	63,160,541.00
210104	Урамшуулал	1,097,766.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	6,797,195.00
210201	Тэтгэврийн даатгал	4,752,531.00
210202	Тэтгэмжийн даатгал	483,674.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	435,496.00
210204	Ажилгүйдлийн даатгал	102,319.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,023,175.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	2,582,199.00
210301	Гэрэл, цахилгаан	497,200.00
210303	Цэвэр, бохир ус	2,084,999.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	63,980,630.00
210401	Бичиг хэрэг	2,810,000.00
210402	Тээвэр, шатахуун	501,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	580,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,090,280.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	57,998,750.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	98,285,703.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	81,792,953.00
210502	Хоол, хүнс	13,914,350.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,578,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,062,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,562,800.00
210604	Урсгал засвар	5,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	967,330.00
210702	Дотоод албан томилолт	967,330.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	560,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	560,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	56,200,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	56,200,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	56,200,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>33,187,400.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	33,187,400.00
222001	Тоног төхөөрөмж	33,187,400.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	340,946,130.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	340,946,130.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,340,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	335,139,130.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,467,000.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хишиг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад анхан шатны баримт бүрдүүлэлтийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 2 дугаар сарын 17-оос 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Сувдаа гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хэрэгжүүлсэн.

Хишиг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго нь нотолгоонд суурилсан чанартай, эмнэлгийн тусламж үйлчилгээ, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг мэдээлэл технологийг ашиглан сайжруулахад оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлагналдаа мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг аймгийн Засаг даргын А/424 тоот захирамжаар 2020 онд батлуулж Төсвийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлэн Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”-ыг тусгасан байна.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хишиг-Өндөр сумын Эрүүл мэндийн төв 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 658,071.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 9,871.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг тайлант хугацааны нийт зардлын 971,242.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 14,568.6 мянган төгрөгөөр материаллаг байдлаар тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хишиг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 167,267.8 мянган төгрөгөөр буюу 18.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, эм боох материал, аж ахуйн материал, машин тоног төхөөрөмж, хуримтлагдсан элэгдэл, хуримтлагдсан үр дүнгийн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	12731.2	12731.2
Урьдчилж гарсан тооцоо	0.0	131184.0	131184.0
Бараа материал	45416.0	130094.6	84678.6
Үндсэн хөрөнгө	709920.7	722224.3	12303.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>755336.7</b>	<b>996234.2</b>	<b>240897.5</b>
Өр төлбөр	0.0	522.5	522.5
Хуримтлагдсан үр дүн	755336.7	995711.7	240375.0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>755336.7</b>	<b>996234.2</b>	<b>240897.5</b>

Дансны үлдэгдэл гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлага 131,184.0 мянган төгрөгөөр өссөн,
- Эм боох материал ковид-19 цар тахал гарсантай холбоотойгоор 33,130.2 мянган төгрөгөөр өссөн;
- Машин тоног төхөөрөмж 71,887.2, аж ахуйн материал 50,864.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн;
- Тайлант үеийн үр дүн 166,745.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн;
- Үндсэн хөрөнгө данс тайлант оны элэгдлийн зардлаас голлон шалтгаалж 125,575.4 мянган төгрөгөөр буурсан;

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Дансны код	Үзүүлэлт	/мянган төгрөг/			
		Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт	Хувь
1	Үйл ажиллагааны орлого	671,828.41	1,407,507.45	735,679.04	110%
11	Татварын орлого	-	-	-	

12	Татварын бус орлого	116,189.49	292,983.53	176,794.04	152%
120004	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	56,873.62	292,983.53	236,109.91	415%
122	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	59,315.87	-	(59,315.87)	-100%
13	Тусламж, санхүүжилтийн орлого	555,638.92	1,114,523.92	558,885.00	101%
1310	Улсын төсвөөс санхүүжих	551,557.10	579,532.80	27,975.70	5%
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,081.82	471,555.93	467,474.11	11453 %
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	45,631.60	45,631.60	
1330	Төсвийн захирагчаас	-	-	-	
1340	НДС-аас санхүүжих	-	17,803.59	17,803.59	
14	Бусад эх үүсвэр			-	
2	Үйл ажиллагааны зардлын дүн	658,115.21	1,167,132.47	509,017.26	77%
21	Урсгал зардал	658,115.21	1,167,132.47	509,017.26	77%
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	652,029.44	1,110,261.17	458,231.73	70%
211	Хүү	-	-	-	
212	Татаас	-	-	-	
213	Урсгал шилжүүлэг	6,085.77	56,871.31	50,785.54	834%
22	Хөрөнгийн зардал	-	-	-	
3	Үйл ажиллагааны үр дүн /3=1-2/	13,713.20	240,374.98	226,661.78	1653%
145	Үйл ажиллагааны бус орлого	-	-	-	
225	Үйл ажиллагааны бус зардал	3,045.34	-	(3,045.34)	-100%
4	Үйл ажиллагааны бус үр дүн /4=145-225/	(3,045.34)	-	3,045.34	-100%
5	Нийт үр дүн /5=3+4/	10,667.86	240,374.98	229,707.12	2153%

Хишиг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нэмэлт санхүүжилтийн орлого өмнөх оноос 467,474.1 мянган төгрөг буюу 114.5 дахин өссөн, нийт орлого 735,679.0 мянган төгрөгөөр буюу 1.1 дахин өсөж төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулж ажилласан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Хишиг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүжилтийн эх үүсвэрийг 873,499.9 мянган төгрөг, үүнээс урсгал зардалд 873,499.9 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Сангийн яамнаас урсгал зардлыг 150,262.5 мянган төгрөгөөр бууруулан 723,237.4 мянган төгрөгөөр баталж тодотголоор 24,580.5 мянган төгрөгөөр бууруулж 698,656.9 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 579,532.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 45,631.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, ЭМДС-аас 69,173.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр үндсэн дансаар улсын төсвөөс 579,532.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 45,631.6 мянган төгрөг, ЭМДС-аас 17,803.6 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны 444.1 мянган төгрөг, нэмэлт дансаар Төрийн болон болог орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандав, тусламж 2,340.0 мянган төгрөг, дээд шатны төсвийн

захирагчаас 335,139.1 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд 3,467.0 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч нийт 971,626.1 мянган төгрөгийн зарцуулалт хийснээс үндсэн дансаар 637,744.5 мянган төгрөгийг зарцуулж 0.9 мянган төгрөгийг төвлөрүүлж, 91.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 637,744.5 мянган төгрөг буюу 91.3 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 37,316.5 мянган төгрөг, ажил олгогчийн НДШ 12,683.8 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 4,320.4 мянган төгрөг, норматив зардал 1,108.5 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 11,210.8 мянган төгрөг, томилолтын зардал 1,115.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардлыг 1,355.2 мянган төгрөгөөр тус тус дутуу, хөрөнгийн зардалд 8,223.2 мянган төгрөгийг зарцуулснаас шалтгаалсан байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулалт нь үйл ажиллагааны урсгал зардал 69,135.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт-3 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөг/*

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71602	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	1,037,941.03	971,182.01	66,759.02	93.6%
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	831,275.73	765,963.94	65,311.79	92.1%
1.2	80109	ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал	44,281.60	44,280.73	0.87	100.0%
1.3	80302	Нэг иргэнд ногдох нормативаар	105,503.70	104,066.90	1,436.80	98.6%
1.4	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	56,880.00	56,870.44	9.57	100.0%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Үндсэн хөрөнгийн бүртгэлд байгаа үлдэх өртөггүй элэгдлээ бүрэн нөхсөн хөрөнгийг өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх.

### 3.8 Аудитын гол асуудал

Хишиг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан local.audit.mn цахим бүртгэлийн хүрээнд мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хишиг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2021 онд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын нийт 1,891,655.5 мянган төгрөгийн 93 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас орлогын 1,226,051.2 мянган төгрөгийн 51, зарлагын 435,408.4 мянган төгрөгийн 21, худалдан авалтын 41,551.4 мянган төгрөгийн мэдээллийг ил тод байршуулаагүй зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Коронавируст халдвар тархсантай холбоотойгоор тайлант онд Эрүүл мэндийн сайд, сангийн сайдын А/337,99 67/А/268 хамтарсан тушаалаар хоёр удаагийн журам, Эрүүл мэндийн сайдын А/605 дугаар тушаалаар “Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс 03, 04 дүгээр тоот тогтоолоор “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай”, Эрүүл мэндийн сайдын А/248, А/415 тоот тушаалаар илүү цагаар ажилласны нэмэгдэл, А/496, А/585 тоот тушаалаар мөнгөн тэтгэмж олгох, А/575, А/581 тоот тушаалаар хөрөнгө гаргах, А/788 тоот тушаалаар эрх шилжүүлэх, А/803 тоот тушаалаар нэг удаагийн мөнгөн урамшуулал олгох тус тус шийдвэрийг гаргасан байна.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудит хийгдээгүй болно.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагын биелэлт 92.5 хувь, 7 зөвлөмжийн хэрэгжилт 79.2 хувьтай байна.

*Хүснэгт-4* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	4	116362.2	3	107533.1	1	8829.1	7.5
Зөвлөмж	7	53291.9	5	42189.2	2	11102.7	20.8
<b>Нийт дүн</b>	<b>11</b>	<b>169654.1</b>	<b>8</b>	<b>149722.3</b>	<b>3</b>	<b>19931.8</b>	<b>11.7</b>

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн НӨАТ-тай худалдан авалт хийх, харилцагч байгууллага, иргэнтэй тооцоо нийлж баталгаажуулах зөвлөмжийг давтан гаргасан тул албан шаардлага хүргүүлээ.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн эсэхийг нягтлах, биелэлтийг тооцох.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 275,293.8 мянган төгрөгийн 10 алдаа зөрчил илэрснээс, 254,460.0 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 19,931.8 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 901.7 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 6 алдаа, зөрчлийн дүн 20,833.5 мянган төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 14,574.4 мянган төгрөгөөс хэтэрсэн тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

##### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Тайлант хугацаанд эмийн зарцуулалт хийгдсэн ч нярвын программд 44,318.9 мянган төгрөгийн зарцуулалт дутуу,
- 131,184.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг журнал бүртгэлд буруу бүртгэсэн,
- Цалингийн зардал, цалингийн өглөг дансны журнал бүртгэлийг 5,327.4 мянган төгрөгөөр алдаатай бүртгэсэн,
- Үндсэн хөрөнгийн элэгдэл 73,629.7 мянган төгрөгөөр илүү тооцоолж бүртгэсэн

##### 4.2 Албан шаардлага

1. Таван сая төгрөгөөс дээж үнийн дүн бүхий 51 удаагийн 1,226,051.2 мянган төгрөгийн орлого, 21 удаагийн 435,408.4 мянган төгрөгийн зарлага, 5 удаагийн 41,551.4 мянган төгрөгийн худалдан авалтын гүйлгээг шилэн дансанд мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4, 6.4.5-д заасны дагуу бүрэн хэрэгжүүлж, үр дүнг тооцох, зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах, Албан шаардлага өгөх.

2. Жилийн эцсийн эд хөрөнгийн Эрүүл мэндийн төвийн даргын А/20 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй комисс томилогдон 12 дугаар сарын 30-нд тооллогыг хийж дууссан бөгөөд тооллого хийгдсэнээс хойш 24,629.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж, бараа материалын хувьд 522.5 мянган төгрөгийн орлого, 12,953.1 мянган төгрөгийн зарцуулалт хөдөлгөөн хийгдсэн ч тооллогын дүн 12 дугаар сарын 31-ний үлдэгдлээр тоологдсон, 8,829.1 мянган төгрөгийн вакцин тоолсон баримт бүрэн бус байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 4 дэх "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх", гэсэн заалттай нийцэхгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу бүрэн хэрэгжүүлж, үр дүнг тооцох, зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах, Албан шаардлага өгөх.

3. Тайлант хугацаанд иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримтгүй нийт 11,102.7 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн, харилцагч 2 байгууллага, иргэнтэй тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй, өмнөх оны зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" заалтыг хэрэгжүүлж байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, холбогдох хууль, тогтоомжийг бүрэн хэрэгжүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарах, Албан шаардлага өгөх.

#### **4.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Зардалтай холбоотой асуудал**

###### Илрүүлэлт:

Батлагдаагүй орон тоонд даатгалын ажилтны орон тоо батлагдаагүй, батлагдсан төсөвт тусгагдаагүй 327.5 мянган төгрөгийн даатгалын ажилтны хавсран ажилласны нэмэгдэл олгож үргүй зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-ийг бүрэн хэрэгжүүлж ажиллах бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

###### Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-ийг бүрэн хэрэгжүүлж ажиллах

##### **2. Бараа материалтай холбоотой асуудал**

###### Илрүүлэлт:

Эрүүл мэндийн газраас ирсэн бараа материалыг тухай бүр орлогод авсан ч тооцоо нийлсэн актгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

###### Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 16.5.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д заасныг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх

##### **3. Авлагатай холбоотой асуудал**

###### Илрүүлэлт:

Тайлант хугацаанд тооцооллыг тухай бүр хийгээгүйгээс 574.2 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
				Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хишиг-Өндөр сумын Эрүүл мэндийн төв	10	275293.5	4	254460	0	0	3	19931.8	0	0	3	901.7